

## АЖЛЫН ДААЛГАВАР

Төслийн нэр	Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл, IDA credit-P174116
Байршил	Монгол Улс, Улаанбаатар
Ажлын даалгаврын нэр	“Эрэлтэд нийцсэн үр чадвар олгох хөтөлбөр”-ийн үнэлгээ хийхэд дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээ
Үйлчилгээний нэр	Дотоодын хувь зөвлөх – “Эрэлтэд нийцсэн үр чадвар олгох хөтөлбөр”-ийн үнэлгээний зохицуулагч
Гэрээний төрөл	Зөвлөх үйлчилгээ
Хэлний мэдлэг:	Монгол, Англи хэл
Гэрээний хугацаа:	12 сар

### ҮНДЭСЛЭЛ

МУ-ын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ) нь ‘Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл’ (ОБҮДХЭТ)-ийг Дэлхийн банкны Олон Улсын хөгжлийн ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгө болон техникийн дэмжлэгтэйгээр 2020-2024 онд хэрэгжүүлж байна. Төсөл нь ажил хайгч болон бичил бизнес эрхлэгчдэд хөдөлмөрийн зах зээл дэх боломжийг хүртээмжтэй хүргэх, КОВИД-19 цар тахлаас үүссэн хямралын үед зохих шалгуур хангасан ажил олгогч болон ажилтнуудад богино хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх зорилготой.

Төсөл нь дараах 4 бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ: 1) Одоогийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний тогтолцоог цогц байдлаар шинэчлэн ажил хайгч болон ажил олгогч нарт “үйлчлүүлэгч-төвтэй” үйлчилгээг хувийн зуучлалын байгууллагуудтай хамтран хүртээмжтэй хүргэх; 2) төслийн хүрээнд сонгосон хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүдийн дизайн, хамаарал ба эрэлтэнд нийцсэн байдлыг бэхжүүлэх; 3) хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, дүн шинжилгээний чанар, хүртээмжийг сайжруулах; 4) Бизнес эрхлэгчид болон ажилтнуудад цар тахлын үзүүлсэн сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор зохих шалгуур хангасан ажиллагчид болон ажил олгогчдод богино хугацааны тэтгэмж олгох бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ.

Бүрэлдэхүүн хэсэг 2-ын сонгосон хөтөлбөрүүдийн дизайн, хамаарал ба эрэлтэнд нийцсэн байдлыг бэхжүүлэх ажлын хүрээнд хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн онцлог шинэлэг үр чадварыг хөгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлнэ. Тодруулбал, “Эрэлтэд нийцсэн үр чадвар олгох хөтөлбөр” (энд Ур чадварын инновацийн хөтөлбөр буюу УЧИХ-ийг ойлгоно)-ийн онцлог нь эрэлтэд суурилсан зөвлөлдөх үүлзалт, салбарын холбоо/зөвлөлүүдийн оролцоо, бие даасан үнэлгээ, нийгэм-бүтээлч зан үйлийн үр чадвар олгох сургалтын нэмэлт модулиуд, мэргэшүүлэх сургалт, өмнөх мэдлэг, үр чадварыг хүлээн зөвшөөрөх үнэлгээ болон бусад шинэлэг зүйлсийг багтаасан.

Хөтөлбөрийн хүрээнд 700-аас доошгүй ажил хайгчдад эрэлтэд нийцсэн мэргэжлийн үр чадвар олгох сургалт болон нийгэм-бүтээлч зан үйлийн үр чадварын сургалт явуулах, 300 хүртэлх ажиллагчдыг мэргэшүүлэх, 200 хүртэлх ажиллагчдын өмнөх мэдлэг, үр чадварыг хүлээн зөвшөөрөх үнэлгээ хийх зэрэг ажлыг хийхээр төлөвлөж байна. ХНХЯ төсөл дууссаны дараа ч энэ хөтөлбөрийг хөдөлмөрийн зах зээлийн гол идэвхтэй хөтөлбөрүүдийн нэг болгон өргөжүүлэхээр төлөвлөж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс “Эрэлтэд нийцсэн үр чадвар олгох хөтөлбөр”-ийг 2023 оны 2 дугаар сард баталсан. ХНХЯ-ны харъяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт (ХНХСҮСИ) нь хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах, хяналт тавих, үр дүнг тайлагнах ажлыг хариуцаж ажиллана. Хөтөлбөр хэрэгжүүлэх удирдамжийг ХНХ-ын сайдын 2023 оны А/145 тоот тушаалаар баталсан бөгөөд удахгүй хэрэгжилтийг эхлүүлэхээр хүлээгдэж байна. Иймд хөтөлбөрийн нарийвчилсан процессын ба үр дүнгийн үнэлгээний дизайныг боловсруулах, хэрэгжүүлэх шаардлага гараад байна.

Хөтөлбөрийн үнэлгээг ХНХЯ-ны Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН) хариуцаж ажиллах бөгөөд үндэсний зөвлөх байгууллага мэдээлэл цуглуулалт, мэдээллийн чанар, дүн шинжилгээ, үр дүнгийн болон процессын үнэлгээний тайланг боловсруулах ажлыг хариуцна. Иймд ХНХЯ нь хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн туршилтын арга хэмжээний үнэлгээний дизайн боловсруулах, үнэлгээ хийхэд ХНХЯ болон зөвлөх байгууллагад дэмжлэг үзүүлэх туршлагатай дотоодын зөвлөхийг сонгон ажиллуулах юм. Ялангуяа, үнэлгээ нь хөтөлбөр хэрхэн хэрэгжсэн талаар нарийвчилсан ойлголт өгч, сайжруулах шаардлагатай чиглэлүүдийг тодорхойлж, хөтөлбөрийн үр шим хүртэгчдэд хүрсэн үр дүнг үнэлэх ёстой.

## **ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА**

### **Зөвлөх үйлчилгээний зорилго:**

Дотоодын зөвлөх нь ХНХЯ болон ОБУДХЭТ-ийн ТХН-ийн удирдамж, хяналтын дор Үнэлгээний зохицуулагчаар ажиллах бөгөөд ДБ-ны баг, ХНХЯ/ТХН болон ХНХСҮСИ-ийн багийн байнгын оролцоо, санал зөвлөмжийг авч, холбогдох бүх талуудтай зөвлөлдөж ажиллана. Тухайлбал, зөвлөх нь үнэлгээний арга зүй, хэрэгслийг боловсруулах, процессын болон үр дүнгийн үнэлгээний гүйцэтгэлийг чанарын өндөр түвшинд хангахын тулд үнэлгээний хэрэгжилтэд хяналт тавихад ХНХЯ/ТХН, ХНХСҮСИ болон зөвлөх байгууллагад дэмжлэг үзүүлнэ. Мөн зөвлөх нь үнэлгээний тайланг эцэслэх, үндсэн үр дүнг нэгтгэн дүгнэх, хөтөлбөрийн цар хүрээг өргөжүүлэхэд хөтөлбөр хэрэгжүүлснээр авсан сургамж болон санал зөвлөмж боловсруулахад зөвлөх байгууллагад дэмжлэг үзүүлнэ.

**Гүйцэтгэх ажлууд:** Зөвлөх нь дараах ажлуудыг гүйцэтгэнэ:

- 1) Дэлхийн банкны болон ТХН, ХНХСҮСИ-ийн багтай хамтран хөтөлбөрийн 1) процессын үнэлгээ болон 2) үр дүнгийн үнэлгээний дизайныг эцэслэн боловсруулах;
- 2) Мэдээлэл цуглуулалтыг төлөвлөх, процессын болон үр дүнгийн үнэлгээний өгөгдлийн чанарыг баталгаажуулах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх стратеги боловсруулах;
- 3) Мэдээлэл цуглуулах арга хэрэгслийг боловсруулах, холбогдох талуудын саналыг тусган сайжруулах, эцэслэх;
- 4) Мэдээлэл цуглуулалт болон мэдээллийн шинжилгээний процесс зэргийг багтаасан үнэлгээтэй холбоотой бүх талын байнгын хяналт, чанарын баталгаажуулалт;
- 5) Судалгааны ахлагч, судлаачдыг бэлтгэх сургалтад туслах, оролцох;
- 6) Цуглуулсан мэдээллийн чанарт ерөнхий хяналт тавих;
- 7) Мэдээлэл цуглуулалт хариуцаж ажиллах зөвлөх байгууллагын нийлүүлсэн бүх бүтээгдэхүүнийг хянаж, санал зөвлөмжийг тухай бүр өгөх;
- 8) Мэдээлэлд дүн шинжилгээ хийх, үнэлгээний тайлан боловсруулах, мөн сургамж, санал зөвлөмжийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх.

Сургалтыг багц хэлбэрээр зохион байгуулахаар төлөвлөж байгаа тул суурь болон төгсгөлийн шатны мэдээлэл цуглуулах ажлыг хэд хэдэн удаа давтамжтайгаар хэрэгжүүлэх шаардлагатай болно.

### **Нийлүүлэх бүтээгдэхүүн:**

Зөвлөх бүтээгдэхүүн нийлүүлэх хуваарийг тусгасан ажлын төлөвлөгөө боловсруулж, ХНХЯ-аар батлуулна. Зөвлөх нь дараах бүтээгдэхүүнийг нийлүүлнэ:

### **Бүтээгдэхүүн 1. 2023 оны 12 дугаар сарын 20-ны дотор:**

- 1.1 Хөтөлбөрийн процессын болон үр дүнгийн үнэлгээний үзэл баримтлалын эцэслэсэн хувилбар;
- 1.2 Процессын болон үр дүнгийн үнэлгээний мэдээлэл цуглуулалт, мэдээллийн чанарын баталгаажуулалт ба дүн шинжилгээ хийх стратеги;
- 1.3 Мэдээлэл цуглуулалт ба дүн шинжилгээг хэрэгжүүлэх зөвлөх байгууллагын ажлын даалгаврын төсөл;

### **Бүтээгдэхүүн 2. 2024 оны 01 дүгээр сарын 17-ны дотор:**

2.1 Үр дүнгийн үнэлгээний аргачлал, суурь мэдээлэл цуглуулах хэрэгслийн эцэслэсэн хувилбар (эхний ээлжийн сургалтад оролцогчдыг бүртгэхээс өмнө заавал эцэслэсэн байх);

2.2 Процессын үнэлгээний аргачлал, мэдээлэл цуглуулах хэрэгслийн эцэслэсэн хувилбар;

**Бүтээгдэхүүн 3. 2024 оны 05 дугаар сарын 15-ны дотор:**

3.1 Үр дүнгийн үнэлгээний суурь судалгааны эцэслэсэн тайлан<sup>1</sup>, слайд (PowerPoint), мэдээллийн чанарын тайлангийн хамт;

3.2 Үр дүнгийн үнэлгээний төгсгөлийн шатны мэдээлэл цуглуулах хэрэгслийн эцэслэсэн хувилбар;

**Бүтээгдэхүүн 4. 2024 оны 09 дүгээр сарын 30-ны дотор:**

4.1 Үр дүнгийн үнэлгээний төгсгөлийн шатны судалгааны эцсийн тайлан, слайд (PowerPoint) хамт;

4.2 Процессын үнэлгээний эцэслэсэн тайлан, слайд (PowerPoint) хамт;

**Бүтээгдэхүүн 5. 2024 оны 11 дүгээр сарын 15-ны дотор:**

5.1. Хөтөлбөрийн процессын болон үр дүнгийн үнэлгээний тайлан, хуримтлуулсан сургамж, зөвлөмжийг тусгасан нэгтгэл тайлан, слайд (PowerPoint).

**Гэрээний хугацаа:**

Зөвлөх нь уг ажлыг нийт ажлын 12 сарын хугацаанд буюу 2023.12.01-ээс 2024.11.30-ны хооронд гүйцэтгэнэ.

**Гэрээний үнэ:**

Гэрээний үнийн дүн нь зөвлөхтэй тохиролцсон тогтсон дүн байна.

Гэрээний нийт үнийн дүн 50,000,000 хүртэл төгрөг байх бөгөөд ажлын даалгаварт заасан ажлуудыг гүйцэтгэхэд шаардагдах бүх зардлууд багтсан байна.

Энэ ажлын даалгаварт заасан аль нэгэн бүтээгдэхүүнийг үндэслэлтэй нөхцөл байдлын улмаас гэрээ дуусгавар болохоос өмнө нийлүүлж амжаагүй бөгөөд үүнээс шалтгаалж гэрээний хугацааг сунгах тохиолдолд зөвлөх нэмэлт зардалгүйгээр бүтээгдэхүүнийг нийлүүлнэ.

**Мониторинг, явцын хяналт, тайлагналтад тавигдах шаардлагууд:**

Зөвлөх нь дээр дурдсан ажлыг ХНХЯ болон ОБҮДХЭТ-ийн ТХН-ийн удирдамж, хяналтын дор гүйцэтгэнэ. Зөвлөхийн ажлын гүйцэтгэлийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

- 1) Ажлын даалгаварт тусгасан ажлуудыг бүрэн гүйцэтгэсэн байдал;
- 2) Төлөвлөсөн ажлуудаа хугацаанд нь хэрэгжүүлсэн байдал;
- 3) Гүйцэтгэсэн ажлын чанар.

**Тайлагналт:**

Зөвлөх нь ОБҮДХЭТ-ийн багт (ХНХЯ/ТХН болон Дэлхийн банк) ажлаа тайлагнаж ажиллана. ОБҮДХЭТ-ийн баг нь эдгээр ажлын даалгаврын дагуу хийгдэх ажлын техникийн болон удирдлагын хяналтыг хариуцна. Зөвлөх нь гэрээний төлбөрийн хуваарьт заасан төлбөр авахын өмнө ХНХЯ болон ТХН-д Бүтээгдэхүүн хүлээж авах маягыг бөглөж ирүүлнэ.

**Төлбөрийн хуваарь:**

Гэрээний үнийн дүн нь энд заасан хугацааг сунгасан эсэхийг үл харгалзан үр дүнд суурилсан тогтсон дүн байна. Дотоодын зөвлөх тохиролцсон бүтээгдэхүүнийг ХНХЯ/ТХН-д бүрэн хүлээлгэн өгсний дараа төлбөрийг доорх хуваарийн дагуу төлнө:

Үе шат	Төлбөрийн нийт үнийн дүнд эзлэх хувь
Бүтээгдэхүүн 1.1; 1.2; ба 1.3	20%
Бүтээгдэхүүн 2.1 ба 2.2	20%
Бүтээгдэхүүн 3.1 ба 3.2	20%
Бүтээгдэхүүн 4.1 ба 4.2	20%

<sup>1</sup> Суурь болон төгсгөлийн үнэлгээний тайлан, процессын үнэлгээний тайлан боловсруулах, эцэслэх ажлыг зөвлөх байгууллага хариуцаж, төслийн дотоодын зөвлөхийн дэмжлэгтэй гүйцэтгэнэ.

**Нөхцөл шаардлагууд:**

Энэхүү даалгавартай холбогдуулан цуглуулсан мэдээлэл, гаргасан тайлан нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ) болон Дэлхийн банкны өмч юм. Сонгогдсон зөвлөх нь энэ мэдээллийг өөрийн судалгаа эсвэл арилжааны зорилгоор ашиглаж болохгүй.

**ШААРДЛАГАТАЙ УР ЧАДВАР, АЖЛЫН ТУРШЛАГА**

Дараах мэргэжил, туршлага, үр чадвар шаардлагатай:

**Боловсрол:**

- Зөвлөх нь эдийн засаг, социологи, төрийн удирдлага болон бусад холбогдох салбарын мэргэжилтэй, магистр болон түүнээс дээш зэрэг цолтой байх;

**Туршлага:**

- Нийгмийн хөтөлбөр, төслүүдийн нөлөөллийн /болон үр дүнгийн/ ба эсвэл процессын үнэлгээний дизайн боловсруулж байсан эсвэл нийгмийн хөтөлбөрүүдийн хяналт шинжилгээ, үнэлгээг өргөн хүрээнд хийж байсан 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай;
- Өмнө нь Дэлхийн банк болон бусад олон улсын донор байгууллагуудын төслийн хэрэгжилт/ /хяналт/үнэлгээ хийж байсан туршлагатай бол давуу тал болно;
- Ажиллах хүчний хөгжил болон хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүдийн талаар туршлагатай бол давуу тал болно;

**Ур чадвар:**

- Бие даан ажиллах болон бусдыг удирдах чадвартай;
- Англи болон Монгол хэлний бичгийн өндөр түвшний мэдлэгтэй;
- Багаар ажиллах, цогц ажлуудыг зохицуулах үр чадвартай.